








ДУА НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

2026 ОНЫ 3-Р САР ХАРИУЦСАН ТАСАГ НЭГЖИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2026.04.06

№	Төлөвлөсөн ажил	Хийгдсэн ажил	Хувь
1	<p>Глобал удирдагч их сургуулийн мэс заслын нийгэмлэгийн тэргүүн С.Оюунгэрэл багш "Мэс заслын шархны менежмент" сэдвээр багц цагийн сургалт зохион байгуулах</p>	<p>"МЭС ЗАСЛЫН МЭРГЭШСЭН СУВИЛАХУЙН НИЙГЭМЛЭГ" НҮТББ-ын тэргүүн СУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн сувилагч С.Оюунгэрэл баг хамт олны бүрэлдэхүүнтэй ирж Дархан-уул аймгийн нэгдсэн эмнэлэг-139, ӨЭМТ-2, СЭМТ-12, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч мэргэжилтнүүд идэвхитэй хамрагдсанаар онцлог байлаа сургалтыг онол дадлага хосолсон хэлбэрээр явуулсан сургалтанд нийт 153 сувилагч хамрагдсан.</p> <p>Багш нар Гэмтэл, Мэс засал, Поли-1 зэрэг тасгуудын боолтын кабинетуудад гардан дадлага дээр харилцан ярилцах, үзүүлэн таниулах орчин үеийн шаардлага хангасан материал, тоног төхөөрхөмжийг хэрэглэх, тохиолдол дээр хэлэлцэх, гардан дадлага хийх хэлбэрүүдээр амжилттай зохион явуулав.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">    </div>	100%
2	<p>"Эмнэлзүйн ховор тохиолдлууд -2026" болон "Эрдмийн чуулган- 2026" эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлэг зохион байгуулах</p>	<p>2026.03.13 өдөр "Эмнэл зүйн ховор тохиолдлууд -2026", "Эрдмийн чуулган -2026" үйл ажиллагааг зохион байгуулагдаж нийт 12 бүтээл оролцсоноос</p> <p>1-р байранд Мэс заслын тасгийн их эмч Б.Батням, их эмч Л.Тэгш-Эрдэнэ, Э.Одмаа, Ж.Навчаа нарын "Мөөгөнцрийн шалтгаант дагзны хуйхны идээт болон дутмагшилт үрэвсэлт өвчнийг/Керион/ далбан эргүүлэх мэс заслын аргаар хуйхыг нөхөн сэргээсэн тохиолдол" илтгэл</p> <p>2-р байранд Мэс заслын тасгийн их эмч Х.Тулгаа, Б.Цэрэнжав, Д.Наранбаатар, А.Бүрkitхан, С.Мөнхлхагва нарын "Нимаier ангилал III хэлбэрийн элэг-цэсний хүүдийн фистулийг оношилж эмчилсэн тохиолдол" илтгэл</p> <p>3-р байранд Мэдрэлийн тасгийн их эмч Б.Ариунжаргал, Ш.Угтахбаяр, Ж. Баярсайхан, ЯТТ-ийн их эмч Т.Бадамцэцэг нарын "Тархины вен синусын тромбоз" илтгэл</p> <p>НЭ-ийн Захирлын нэрэмжит "Шилдэг эмч" шагналаар МЭЭ тасгийн эрхлэгч Г.Ганчимэг шалгарсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>	100%

3	<p>“Тоног төхөөрөмжийн ашиглалт болон аюулгүй ажиллагаа” сургалт зохион байгуулах</p>	<p>Сувилагч мэргэжилтнүүдийг эмнэлгийн тоног төхөөрөмжийг зөв, аюулгүй ашиглах сургалтад хамруулснаар 2026оны II улиралд тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг бууруулж, учирч болох аюул эрсдэлээс сэргийлэх, мөн ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор бүх тасаг нэгжүүдэд ажлын байран дээр дадлага сургалт явуулсан. 22 тасаг нэгжүүдээс 14 тасаг нэгжүүдийн 65 ажилтан хамрагдсан.</p> 	100%
4	<p>Дэлхийн эмч нарын баярын өдрийг тохиолдуулан үйл ажиллагаа зохион байгуулах</p>	<p>Жил бүрийн 3 сарын 30 өдөр Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан шинэ эмч нарыг хамт олонд танилцуулах, амжилт бүтээлээ хуваалцах, хамт олноо манлалагч эмч нарыг алдаршуулах хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • “Авьяаслаг их эмч” Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн их эмч Д.Өлзийбаяр • “Хамт олны хүндэтгэл хүлээсэн их эмч” Гэмтлийн тасгийн их эмч Ч.Даваадорж • “Эерэг хандлагатай их эмч” Хүүхдийн тасгийн эрчимт эмчилгээний их эмч Ж.Батчимэг • “Бүтээлч их эмч” Дүрс оношилгооны тасгийн дурангийн их эмч М.Мандухай • “Зарчимч хариуцлагатай их эмч” Поликлиник-1 тасгийн зүрхний их эмч Г.Бадамлянхуа <p>Эмч мэргэжлийг олон нийтэд сургалчлах чиглэлээр НЭ-ийн олон нийтийн сүлжээний хаягт 3 рийл бичлэг хийж байршуулсан.</p> <p>Мөн ДУА-ийн ЭМГ-ын эмч нарын баярын хурлаар Нэгдсэн эмнэлгээс 11 эмч эрүүл мэндийн салбарын болон аймаг, сумын шагналаар шагнагдсан. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан- 2 эмч • Эрүүл мэндийн яамны жуух бичиг- 2 эмч • ДУА-ийн ЗД-ын жуух бичиг- 6 эмч • Дархан сумын ЗД-ын жуух бичиг- 1 эмч 	100%
5	<p>“Асрагч нарын баримжаа олгох цуврал сургалт” зохион байгуулах</p>	<p>Нэгдсэн Эмнэлгийн үйлчилгээний ажилтануудад эмнэлгийн байгууллагын онцлогт суурилсан цэвэрлэгээ үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхэд шаардлагатай баримжаа олгох сургалт тусгайлсан төлөвлөгөөний дагуу явагдаж байна. 3-р сарын сургалтаар “Ёс зүй харьцаа, хандлага, Хөдөлмөр, аюулгүй байдал, Эрсдлийг үнэлэх хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр Сувилахуйн албаны дарга С.Мөнхцолмон, Эрсдлийн менежер Л.Мөнхтуул, ХАБАЭ ажилтан Р.Оюунтуяа нар сургалт хийв . Нийт 31 асрагч хамрагдсан</p>	100%



Гамшгийн үеийн дуут дохиогоор ажиллах нэгдсэн сургалт зохион байгуулах

Гамшгаас хамгаалах хуулийн 34 дүгээр зүйл, Монгол улсын засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулилтыг ОБГ-ын мэргэжилтэн О.Батсайхантай хамтран зохион байгуулсан.

Тус сургалтаар улс орон даяар зарласан зарлан мэдээллийн дохионы дагуу ажилтнууд ажлын байрнаасаа аюулгүй байдлаа ханган, аврах гарцаар хэрхэн гарч аюулгүй талбай буюу цугларах цэгт цуглах дадлага сургуулилтыг хийсэн ба нийт алба, тасгийн 215 эмч, эмнэлгийн ажилтан болон гамшгаас хамгаалах мэргэжлийн бүлгэмийн бие бүрэлдэхүүн оролцов.



100%

6

Тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр “Сүрьеэгээс сэргийлье” өдөрлөг:
 Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хүн бүрийн идэвхи оролцоо, манлайлал, эрүүл мэндийн мэдлэг хандлага чухал нөлөөлдөг. Сүрьеэгийн тасаг, Поликлиник-2 тасгууд хамтран иргэд үйлчлүүлэгчдэд "Сүрьеэ өвчин, урьдчилан сэргийлэлт" -ийн мэдлэг олгох, зөв хандлагыг төлөвшүүлэх өдөрлөг зохион байгуулж, иргэдэд амны хаалт, гарын авлага, витамин С тараан мэдээлэл түгээн ажилласан.




100%

7



Дэлхийн усны өдрийн уриа-УС БА ТЭГШ ЭРХ:



Дэлхийн усны өдрийг тохиолдуудан иргэн бүр усны үнэ цэнийг ухамсарлан, усны зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, усны нөөцийг хамгаалах үйлсэд идэвхтэй оролцохыг уриалж, амбулатори болон хүүхдийн тасгаар үйлчлүүлэгч 84 иргэдэд "Усны үнэ цэнэ, усаа гамная" гарын авлага, цэвэр ус, мэдээлэл өгч ажилласан.




8 Шинэ сувилагч нарын уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах

Шинэ сувилагч нараа угтан авах үйл ажиллагааг зохион байгуулав. Уг үйл ажиллагаанд нийт 5 шинэ сувилагч нарыг хамруулсан.

100%

			
9	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын багийг чадавхижуулах ажлын хүрээнд “Эрсдэл болон тохиолдол бүртгэх, хариу арга хэмжээ авах нь” сургалт зохион байгуулах</p>	<p>Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанаас тасаг нэгжийн чанарын багийн гишүүдэд чанарын суурь ойлголт олгох, эрсдэл болон тохиолдлыг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх, сайжруулах, арга хэмжээ авах чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулав. Уг сургалт нь чанарын үндсэн ойлголтыг эзэмшүүлэх, тохиолдол эрсдлийг тодорхойлох, RCA, CAPA хэрэгжүүлэх чадвар олгох, чанарын багийн үүргийг тодорхой болгох талаар мэдээлэл өгсөн.</p> 	100%
	“Эрүүл зөв хооллолтын сургалт зохион байгуулах”	Хэрэгжээгүй	0%
	Давсны хэрэглээг бууруулах өдөр: “Давсны зөв хэрэглээ” өдөрлөг зохион байгуулах	4-р сард хойшлогдсон	-
	Үйлчлүүлэгчдэд “Боломж үргэлж байдаг- Хорт хавдраас сэргийлье” нээлттэй өдөрлөг	4-р сард хойшлогдсон	-
Нэмж хэрэгжүүлсэн ажил			
10	<p>Гэмтэл Согог судлалын төвийн хамтын ажиллагааны хүрээнд эмнэлгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах</p>	<p>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Дархан Нэгдсэн эмнэлгийн захирал Б.Мөнхбат нар /2026-03-20/ хүн амд үзүүлэх төрөлжсөн нарийн мэргэшлийн тусламж үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны хүрээнд нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах, дэмжлэгт удирдлагаар хангах, эмчилгээний орчин үеийн аргыг нэвтрүүлэх, хамтарсан үзлэг оношлогоо, мэс засал эмчилгээ хийх, сэлгэн ажиллуулахад чиглэгдэж байгаа бөгөөд ГССҮТ-ийн эмч нарын баг Дархан –Уул аймагт ажиллаж үзлэг, оношилгоо болон хамтарсан мэс заслыг хийж мөн эмч ажилчдад сургалт зохион байгуулсан.</p>	100%



Төлөвлөгөөнд нийт 12 ажил төлөвлөснөөс хойшлошдсон 2 ажил, хэрэгжээгүй 1 ажил, нэмэлтээр 1 ажил хэрэгжүүлэ 83% биелэлттэй ажилласан.

Тайлан гаргасан:

Хүүхдийн тасаг, Мэдрэлийн тасаг, Эм зүйн алба